

# I-V ангийн унших чадварын агуулгын залгамж холбоо

| Анги  | 1-р анги  | 2-р анги   | 3-р анги  | 4-р анги  | 5-р анги   |
|---|---|--|---|---|--|
| <b>УНШИХ ЧАДВАР</b>                             |   |  |   |   |  |
| Унших чадварт тавигдах шаардлага уншлагын чанар | Зөв унших   | Унших хурдаа нэмж, бусдад ойлгогдохоор зөв, унших  | Өгсөн эхийг бусдын дэмжлэгтэй, ойлгож унших   | Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах   | Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах  |
| Эхийн агуулгыг ойлгосноо харуулах               | 1.1.а. Өгүүлбэр, эхээс танил биш үгийг олж, утгыг нь таамаглах  | 2.1.а. Танил биш үгийг сурах бичгийн тайлбараас цагаан толгойн үсгийн дарааллаар үгээ сонгох, утгыг мэдэх          | 3.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, агуулгыг ойлгох                               | 4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох                                 | 5.1а. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсний учрыг тайлбарлан дүгнэх  |
|   | 1.1.б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах | 2.1б. Уншсан шүлэг, өгүүлэг, үлгэр, зүйр цэцэн үг зэрэг эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах       | 3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүлэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах  | 4.1б Уншсан эхийн болон үлгэр, өгүүлэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах             | "5.1.б. Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах<br>5.1.в.Уншсан жүжгийн гол санааг тайлбарлах" |
|   | 1.1.в. Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочих (эхлээд? дараа нь, эцэст нь?)                              | 2.1.в. Уншсан үлгэр, өгүүлэгийн үйл явдлыг дарааллын дагуу тоочих  | 3.1в. Уншсан үлгэр, өгүүлэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах  | 4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүлэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах                              | 5.1.г. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн утгын холбоо хамаарлыг тайлбарлах   |
|   |   |  |   | 4.1г Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрслэлийг тайлбарлах                     | 5.1.д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах                                       |
|   |   |  | 3.1г. Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах  | 4.1д. Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгах                              | 5.1.е. Үлгэрт амьдралын бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгах                              |
|   | "1.1.г. Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих "  | 2.1.г. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах   | 3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах   | 4.1е. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гар-сан өөрчлөлтийг харьцуулах       | 5.1.ж. Уншсан эхийн баатруудын харилцан ярианаас тэдний зан чанарыг дүгнэх   |
|   |   | 2.1.д. Талархал, мэндчилгээ, товч анкет, гэр бүлийн танилцуулга, заавар зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах | 3.1е. Талархсан захидал, зорилгодоо хүрэх төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах | 4.1ж. Урилга, уриалга, номын танилцуулга, сонины мэдээ, талархлын захидал зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах | 5.1з. Захидлаас нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх   |
|   | 1.1.д. Цээжилсэн хэл зүгш-рүүлэх үг, балгэ дэмбэрлийн үг, шүлгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших           | 2.1.е. Цээжилсэн шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших                         | 3.1ж. Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч, мэдрэмжээ илэрхийлэн уран унших   | 4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах                             | "5.1и. Зохиолчийн санааг мэдэрч, уран унших  |
| Бүтээлчээр ойлгож унших                         | 1.1.е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлөх  | 2.1.ж. Өгсөн зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг ургуулан төсөөлөх  | "3.1з. Үлгэр, өгүүлэгийн үйл явдлыг уншихдаа гол баатрын хэлэх үгийг ургуулан бодож, төсөөлөх"                                | "4.1и. Зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх"   | 5.1к. . Үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг ургуулан бодож төсөөлөх   |
|   |   | 2.1.з. Өгсөн зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах   | 3.1и. Уншсан үлгэр, өгүүлэгийн гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглах   | 4.1к. Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах   | 5.1л. Онцгойн далд утгыг үндэслэлтэй таамаглах   |

Тайлбар: Дээрх суралцахуйн зорилтууд нь ялгах, харьцуулах, дүгнэх чадварын хүрээнд боловсруулагдсан ажлын хуудас ба өмнөх ангийн харгалзах суралцахуйн зорилтуудтай залгамж холбоотой болох нь хүснэгтээс харагдаж байна. Иймд өмнөх ангийн харгалзах суралцахуйн зорилтын ажлын хуудасуудыг ажиллах бүрэн боломжтой.



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр ..... цаг

## Бодит байдал гэж юу вэ?



Бодит амьдрал дээр байдаг бидний харсан үзсэн зүйл юм.



## Уран сэтгэмж гэж юу вэ?

Бодит амьдрал дээр байдаггүй зүйлийг урнаар төсөөлөн бодсоныг хэлнэ.



1 Өгүүлбэрийг уншаад зөв харгалзуулаарай.

Шидэт малгай бүтээв.



Нисдэг тэмээ үүлэн дээр байдаг.



Өвөөгийн хүрэн тэмээ сүрлэг том биетэй.

бодит байдал

уран сэтгэмж

Ах шүхрээр буув.



Хээр мориороо салхи татуулан давхив.



Нисдэг бор морио унав.

2 Зургийн аль нь бодит байдал, аль нь уран сэтгэмж болохыг ажиглаад, өгүүлбэр зохиож бичээрэй



Blank lines for writing the answer to question 2.



Blank lines for writing the answer to question 2.



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр ..... цаг

“Шидэт малгай” өгүүллэгийг ойлгож уншаарай. Уншихдаа:

- ❖ Уран сэтгэмж, бодит байдлыг ялган будаарай.
- ❖ Утгыг мэдэхгүй үгийг тэмдэглээрэй.

### ШИДЭТ МАЛГАЙ

Биднийг дөрөвдүгээр ангид орох намар Дундговь аймгаас нэг хүүхэд шилжиж ирлээ. Тэр бид хоёр дотно найзууд боллоо. Учир нь хоёуланд маань нэгэн ижил зүйл байсан юм. Би ангийнхандаа үлгэр ярьж байгаад зарим хэсгийг нь мартчихвал Дондог шууд л зохиогоод ярьчихна. Ёстой л ангайтал ярьж түс хийтэл инээд алдуулна шүү дээ.....

1

Дондогийн яриаг төсөөлөн бодоорой. Бодит байдал, уран сэтгэмж аль нь болохыг будаарай.

...Нэгэн удаа Дондог говьд луу гэж амьтан байдаг тухай ярилаа. Тэр луу нь найман бөхтэй, дөрвөн том далавчтай. Амнаас нь гал дүрэлзээд л уурлахаараа ургаа модыг хугарч унатал сүүлээрээ шавхуурддаг. Сайхан ааштай үедээ говийн хүүхдүүдийг нуруундаа суулгачхаад л номин хөх тэнгэрээр зугаацуулж явдаг гэнэ.



Бодит байдал буюу амьдрал дээр байдаг зүйл

Уран сэтгэмж буюу амьдрал дээр байдаггүй зүйл

*Үргэлжлүүлэн уншъя:*

Ингээд л лууны тухай яриа ид өрнөж байтал багш орж ирлээ. Тэгтэл нэг нь: -Багш аа говьд аварга том, нисдэг луу байдаг юм уу? гэж асуулаа. Багш инээгээд: -Дондог тэгж байна уу? гэлээ. Дондог тэгтэл:

-Багш аа! манай Лувсан өвөө хүрэн атаа Луу гэж нэрлэсэн байхгүй юу. Өвөөгийн хүрэн лууны тухай найзууддаа ярьсан юм гэдэг байгаа....



Бодит байдал буюу амьдрал дээр байдаг зүйл

Уран сэтгэмж буюу амьдрал дээр байдаггүй зүйл

Бас нэгэн удаа зургийн хичээл дээр малгай зурлаа. Багш бидний дундуур явж байгаад Дондогийн зургийг үзээд:

-Энэ чинь харин сонин малгай байна даа. Ингэж л урнаар сэтгэж зурах хэрэгтэй гэж магтлаа. Нээрээ л далбийсан хүрээтэй, шовойсон өндөр оройтой хачин янзын малгай байв. Дондог надад яг ийм малгай байсан юм.





## Үргэлжлэл

Манай найзууд миний малгайг "Марзан шовгор" гэдэг байлаа. Марзан шовгор малгайг өмссөн хүүхдийн толгойд ид шид орж ирдэг байсан юм. Нэг зун ахтайгаа мөнгөн цагаан онгоцоо хөлөглөн толгойгоо цухуйлгачхаад од шүүрэн алдан нисэж явлаа шүү дээ...



Бодит байдал буюу амьдрал дээр байдаг зүйл

Уран сэтгэмж буюу амьдрал дээр байдаггүй зүйл

... Гэтэл хавирган саранд марзан шовгор малгай минь өлгөгдөж унаад би толгой нүцгэн хоцордог байгаа гэж Дондогийг ярихад: Ха ха, хи хи. Ёстой л жинхэнээсээ худал хэлж орхилоо доо гэж анги дүүрэн инээлдлээ.



О.Сундуй

Бодит байдал буюу амьдрал дээр байдаг зүйл

Уран сэтгэмж буюу амьдрал дээр байдаггүй зүйл

2 Дондог говьд үнэхээр нисдэг аварга луу байдаг тухай ярьсан уу? Ямар лууны талаар ярьсан бэ?

---



---



---

3 Багш яагаад Дондогийг "ингэж л уран сэтгэх хэрэгтэй" гэж магтсан бэ?

---



---



---



Сурагчийн нэр: .....


Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр ..... цаг



Бодит амьдрал дээр байдаггүй дүр, үйл явдлыг дүрсэлснийг уран сэтгэмж гэнэ.

1

Үлгэрт гардаг дараах зургуудыг ажиглаад, бодит байдал болон уран сэтгэмжийн аль нь болохыг тэмдэглээрэй. ✓



Эхийг уншихдаа бодит байдал эсвэл уран сэтгэмжийн аль болохыг бодоорой.

### Ялимгүй маргаан

Энэ хорвоо дээр зөрчил маргаангүй юм гэж үгүй болой. Ерийн нэг сурах бичгийн тоонууд хүртэл маргалддаг ажээ. Энэ бүхэн нэгийн тооноос л болсон хэрэг. Тоо тооны дундаас Нэгийн тоо ер нь их онгируу.

Тэр “Ертөнцийн бүх юм Нэгийн тооноос эхэлнэ. Тэгш сондгой бүх тооны тэргүүлэгч нь би юм. Хэрэв би байхгүй бол хэн ч юу ч хэмжиж чадахгүй” гэж ярих дуртай. Шинэ маргаан эхлэх өдөр нэгийн тоо гурвалжин, гонзгой нийлсэн хэдэн шугамтай танилцаж гэнэ. Гэтэл шинэ танилуудынх нь хэмжээс томоо гэгч Тэгээс эхэлсэн байх юм. Нэгийн тоо мэнчийтлээ уурлаж: - Ямар эргүү тэнэг нь миний өмнө тэгийг бичдэг байна. Энэ тэг чинь ямар ч утга учиргүй хоосон зүйл шүү дээ гэж давшлав. Тэг маш тайвнаар: - Би ямар ч утгагүй, хэнд ч хэрэггүй гэж үү? гэхэд нэгийн тоо уухилан: - Тийм ээ, тийм. Чи бол жинхэнэ хоосон зүйл. Арван Тэгийг хооронд нь нэмье. Хэд гарч байна вэ? Ганцхан тэг. Бүр зуун тэгийг нэмье. Бас л ганцхан тэг. Утгатай учиртай гэдэг чинь би шүү дээ. Арван нэгийг хооронд нь нэмье. Арав гарч байна шүү дээ гэтэл Тэг хариуд нь юу ч хэлсэнгүй. Зөвхөн толгой дохисоор л хааяа доогтой жуумалзсаар л байлаа. Тийнхүү Тэгийн тоо нь Нэгийн тоонд гомдож сүйд болсон ч үгүй. Харин түүнийг нэг сайн хашраахаар бүх тэгийг дагуулан, номын ертөнцөөс гарч оджээ. Энэ явдал тооны хааны сонорт хүрч, хаантан тоочин алиа салбадай

нараа дагуулсаар номын ертөнцөд заларчээ. Аялан явах зуураа хаантан бараа бологчдоороо тоо бодууллаа. Алиа салбадай босоод 9 дээр 1-ийг нэмлээ. Хариу нь 1 гарчээ. Удаах салбадай босоод 99 дээр 1-ийг нэмжээ. Хариу нь бас л нэг гарчээ. Нэгийн тоо учиргүй сандрав. Бусад тоонуудын дунд шивэр авир яриа үүсэв.

Хаантан захирангүй дуугаар: 399 дээр 1-ийг нэм гэлээ. Тэнцүү 4 гарчээ. 4-ийн тоо бараг хашхирах шахам дуугаар: - Алиа салбадай нар зөв бодож байна. Ард минь зогсох тэгүүд л алга. Яагаад тэгүүд алга болсныг ярьж өгөх гэтэл... Бүх тоо зэрэг шахам: - Нэг ... нэг. Онгиороо сагсуу нэг гэж шуугилдлаа.

О.Сундуй

2 Асуултад хариулаарай

- Тэг яагаад толгой дохисоор, хааяа доогтой жуумалзсаар байсан бэ? .....
- Тэг яагаад бусад тэгээ дагуулан номын ертөнцөөс гарч одсон бэ? .....
- Тэггүйгээр нэг болон бусад тоо ямар байдалд орсон бэ? Юунаас болов? .....


3 Дараах хэсгүүдийг уншаад 1, 4 болон бусад тоонуудыг хүншүүлэн, тэдний төрх байдал ямар байхыг төсөөлөн зураарай.

| 1-ийн тооны төрх байдал   | 4-ийн тооны гадаад төрх   | Бусад тооны гадаад төрх   |
|---|---|---|
| Алиа салбадайнүүд 9 дээр 1-ийг нэмлээ. Бас 99 дээр 1-ийг нэмлээ. Хариу нь ердөө 1 гарчээ. Нэгийн тоо учиргүй сандрав. | 4-ийн тоо бараг хашхирах шахам дуугаар: - Тэд зөв бодож байна. Ард минь зогсох тэгүүд л харин алга гэв. | Бусад тоонуудын дунд шивэр авир яриа үүсэв. Бүх тоо зэрэг шахам: - Нэг, онгиороо сагсуу нэг гэж шуугилдлаа. |
|   |   |   |

4 Ялимгүй маргаан эх уран сэтгэмжит эх мөн үү?

- а. тийм      б. үгүй

5 Тийм бол яагаад? Үгүй бол яагаад? гэдгийг тайлбарлан бичээрэй.



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр ..... цаг

**Харамч эр ба түүний алт**

Гоонь эр алтан зооснуудаа хашааныхаа чулуун дор нуудаг байв. Шөнө бүр унтахын өмнө нуусан алтан зоосоо гаргаж тоолно.

Нэг өдөр хулгайч түүнийг харчхав. Харанхуй болмогц хулгайч бүх алтан зоосыг нь авлаа. Маргааш нь гоонь эр насаараа хураасан алтан зооснуудаа алдсанаа мэдээд чангаар уйлж гарчээ. Түүний уйлахыг сонссон хөрш нь юу болсныг асуув. Гоонь эр цурхиран цурхиран уйлж, учир байдлаа тоочив. Учрыг мэдсэн хөрш: - Алтан зооснуудаа гэртээ хадгалахгүй дээ. Хэрэглэх болбол ойрхон амар шүү дээ! гэв. Харамч эр: - Хэрэглэх ээ? Би хайран алтан зооснуудаа хэзээ ч элдэв юманд хэрэглэхгүй гэж боддог байсан юм.” гэв.

Үүнийг сонссон хөрш нь алтан зоос байсан нүх рүү нь чулуу шидэнгээ: - Тэгвэл чулуу л хадгалаач дээ. Хэрэглэхгүй юм бол алтан зоос ч байсан чулуу ч байсан, ялгаа юу байна аа?” гэжээ.

гоонь эр – ганц бие эр хүн

1 Дараах үгсээс сонгож, гоонь эр, хөрш хоёрын зан чанарыг тодорхойлоорой.

харамч, тусархуу, зожиг, ухаан муутай, ухаантай, тэнэг, сул дорой, нарийн

Гоонь эрийн хийсэн үйлдлүүд

Хөрш эрийн хийсэн үйлдлүүд

.....  
 .....  
 .....  
 .....

.....  
 .....  
 .....  
 .....




Гоонь эрийн зан чанар

Хөршийн зан чанар

.....  
 .....

.....  
 .....



2 Үгсийг эвлүүлэн асуух өгүүлбэр бүтээгээрэй. Асуултад хариулж бичээрэй.

байсан уу?

Харамч

ч

харамладаг

эр

алтаа

өөрөөсөө

.....  
 .....